ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 04 өдөр Дугаар А/14 Шивээговь сум

Байгууллагын “Чанарын бодлого”-ыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” Олон улсын стандартыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын Засаг даргын Тамгын газарт “Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015” Олон Улсын стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны Магадлах-1 аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагын “Чанарын бодлого”-ыг шинэчлэн баталсугай.

2.Байгууллагын “Чанарын бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

3.“Чанарын бодлого”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, олон нийтэд мэдээллэн ажиллахыг ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/17 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ЦЭРЭНДОРЖ

D:\2022 oni barimt\TDarga\tushaal

422220288

Засаг даргын Тамгын газрын даргын
2022 оны 07-р сарын 04-ны өдрийн
А/114 дугаар тушаалын хавсралт

УСА0004 9018441

ЧАНАРЫН БОДЛОГО

Бид сум орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлогыг иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан боловсруулан хэрэгжүүлж, Олон Улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан харилцагч байгууллагуудтай хамтран иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, албан хаагчдын мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хурдан шуурхай хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг өмнөх оноос 0,5 хувиар нэмэгдүүлнэ.

Зорилт 1

Сумын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэн сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 90,0-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэх

Зорилт 2

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, иргэдийн оролцоонд тулгуулан хог хаягдлын менежментийг сайжруулан ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.

Зорилт 3

Ур чадварт суурилсан судалгааг хийж, ажилтан албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах

Зорилт 4

Олон Улсын стандартад суурилсан төрийн үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулах

Зорилт 5

Олон Улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа сайжруулан ISO 9001:2015 стандарт ‘Чанарын менежментийн тогтолцоо”-нд давтан баталгаажуулалтын аудит хийлгэх

БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА

Шивээговь сумын Засаг Даргын Тамгын газар нь Олон улсын стандартыг нэвтрүүлж, төвийн бүсийн шилдэг манлайлагч байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Манай байгууллага нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд оновчтой бодлого төлөвлөлт, бүтээмж, шинэчлэлд тулгуурласан, иргэнээ дээдэлсэн суралцагч хамт олон байна.

Үнэ цэнэ:

- Шинэчлэл ба мэдлэг
- Иргэний дээдлэл
- Багийн ажиллагаа ба манлайлал
- Нийгмийн хариуцлага
- Эерэг хандлага, ёс зүй